

ХАР БАЛГАСААС ОЛДСОН ХӨЛӨГТ ТОГЛООМ

У. ЭРДЭНЭБАТ¹, Т. БАТБАЯР², Д. СОДНОМЖАМЦ³


¹ МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологи тэнхим, u_erdenebat@num.edu.mn

² ШУА-ийн Археологийн хүрээлэн, tumirochirbatbayar@yahoo.com

³ МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологи тэнхим, d.soogii_9@yahoo.com

Түлхүүр үгс: Монголын археологи, дундад зууны хот суурин, Орхоны хөндий, Хар Балгас, уламжлалт хөлөгт тоглоом

ТОВЧ АГУУЛГА: Энэхүү өгүүлэлд Монгол-Германы Орхон Экспедицийн (MONDOreX) 2009-2010 оны хээрийн шинжилгээний малтлагын явцад Архангай аймгийн Хотонт сумын нутаг Уйгурын Хар Балгасаас шинээр олдсон хөлөгт тоглоомын олдворын харьцуулсан судалгааны үр дүнг нийтэлжээ. Хар Балгасаас олдсон хөлөг дээрх дүрс Орхоны хөндийд нийслэллэж явсан Уйгурын төрийн шаашин болох манихейн ёсны бэлгэ тэмдэг болох бөгөөд уг тоглоом анх Умард Африкт үүсч, Өрнөд Азиар дамжин Европ, Дундад Ази руу тархаж, Монгол газар анх Уйгуруудын дунд түгэн дэлгэрч, улмаар хожмын монгол үндэстний хөлөгт тоглоомын нэгэн төрөл болж уламжлагдан хөгжсөн байна.

Уйгурын хаант улсын сүр жавхлалт нийслэл Ордубалык буюу нутгийн зон олны нэрлэдгээр Хар Балгасыг археологийн талаар шинжлэн судалж буй Монгол-Германы Орхон шинжилгээний ангийн 2009-2010 оны хээрийн шинжилгээний ажлын явцад НВ2 хэсгийн малтлагаас дээр нь тус бүр адилхан  - дүрсийг сараачиж хөлөгт тоглоомын өрөг болгосон хоёр бүтэн, нэг хагархай тоосгон хавтан, мөн энэ дүрсийг сараачиж сийлсэн бог малын шагай, тэдгээрийн ойр орчмоос уран гоёмсог хийцтэй, зориуд хоёр өөр өнгөтэйгөөр урлаж хийсэн шилэн хасаа нийт есөн ширхэг олдсон билээ (Эрдэнэбат, Батбаяр 2009; Эрдэнэбат, Батбаяр, Дашдорж 2010). Эдгээр нь манай оронд урьд өмнө явуулсан археологийн малтлага судалгаанд тохиолдож байгаагүй нэгэн зүйлийн хөлөгт тоглоомын шинэ олдвор болох бөгөөд олдвор бүрийг тодорхойлбол:

Тоглоомын хөлөг

1-р хөлөг. Нарийн ширхэгтэй саарал шавраар хийн шатааж бэхжүүлсэн хөх өнгийн тэг дөрвөлжин хавтан тоосгоны нүүрэн талын төв голд тэгш өнцөгт гурван

дөрвөлжин нүдийг дотор дотор нь багтаан, тэдгээрийн өнцөг булангууд хийгээд талуудыг хооронд нь хөндлөн болон ташуу шугамаар холбосон хийц загвартай. Уг дүрс тэмдгийг хурц нарийн үзүүр бүхий багажаар гүн хонхор зураас гарган сийлэх аргаар дүрсэлжээ. Гурван нүдний хамгийн дотор талынх нь 5,5 см х 6,5 см, голынх нь 11 см х 12,5 см, гадна талынх нь 17,5 см х 20 см бөгөөд гадна ба дунд талын дөрвөлжингийн талуудын хооронд дунджаар 3-4 см, дунд ба хамгийн дотор талын дөрвөлжингийн талуудын хооронд 2-3,5 см зайтай. Эдгээрийн харалдаа байрлах өнцөг болон талуудыг холбосон ховил зураасын урт дунджаар 5,5-9,5 см, өргөн 0,2 см, гүн 0,1 см. Хөлгийг дүрсэлсэн уг тоосго 4 хэсэг болон хагарсан байсан ба хагархайн ирмэгээс багахан эмтэрч үгүй болжээ. Гэхдээ хэсгүүдийг эвээр нь нийлүүлэхэд үндсэндээ бүтэн болох тул хэмжээг бүрэн тодорхойлох боломжтой. Эвлүүлсний дараа хэмжихэд урт нь 32 см, өргөн нь 32 см, зузаан нь 6,5 см байна. Хүндийн жин нь ойролцоогоор 9 кг. Уг тоглоомын хөлөг Хар Балгасын цайзат их хэрмийн доторх суварганы дэргэдэх хоёр шороон овгорын өмнө талын (зүүн барилга) байгууламжийн төв хэсгээс буюу НВ 2 малтлагын DD 36 талбайгаас олдсон (Зураг 1 б).

2-р хөлөг. Нэгдүгээр хөлгийн ижил хийц загвартай боловч тоосгоны нүүрэн талыг бүхэлд нь эзлүүлэн дүрсэлжээ. Гурван нүдний хамгийн дотор талынх нь 9 см х 11 см, голынх нь 20,5 см х 21,5 см, гадна талынх нь 27 см х 28 см бөгөөд гадна ба дунд талын дөрвөлжинг 3-4,5 см, дунд ба хамгийн дотор талын дөрвөлжинг 5-6,5 см тус тус зайтай зуржээ. Харалдаа өнцөг болон талыг холбосон ховил зураасын урт 10-12 см, өргөн 0,2 см, гүн 0,1 см. Тоглоомын хөлгийг дүрсэлсэн уг тоосгыг нарийн ширхэгтэй саарал шавраар хийж, шатааж бэхжүүлсэн, хөх саарал өнгөтэй. Дөрвөн хэсэг болж хагарч салсан байх бөгөөд хооронд нь эвлүүлэхэд бүтэн болно. Эвлүүлсний дараа хэмжихэд 30 см урт, 31 см өргөн, 5,5 см зузаан хэмжээтэй байна. Уг хөлгийг эдэлж хэрэглэж байсан бололтой, дүрслэл нь нэлээд элэгдэж бүдгэрсэн байхаас гадна тоосгоны хөвөөг тойроод эмтэрч гэмтсэн байдалтай байв. Уг тоглоомын хөлөг Хар Балгасын цайзат их хэрмийн доторх суварганы дэргэдэх хоёр шороон овгорын хойд талын барилгын (баруун барилга) нүүрэн талаас буюу НВ 2 малтлагын DD 13 талбайн 87 дугаар өрөгт, малталтын 8 дугаар үеийн гүнд В 2089 дүгээр хөрснөөс олдсон. Хүндийн жин нь 7 кг орчим. Олдворын дугаар: 23/08/4 буюу 1282 дугаартай болно (Зураг 1 а).

3-р хөлөг. Дээрх хоёрын ижил өөр нэг хөлгийн ойролцоогоор 1/4 хэсэг буюу нүүрэн талдаа хурц үзүүртэй зүйлээр сараачиж гаргасан хөлөгний тал дүрслэлтэй тоосгоны хагархай. Энэхүү хадгалагдан үлдсэн хэсгээс харахад хөлгийн аль нэг талын булан бөгөөд тэгш өнцөгт гурван нүдийг хооронд нь ижилхэн 2-2,5 см зайтай дүрсэлсэн болох нь мэдэгдэнэ. Дүрсний харалдаа өнцгийг холбосон ховил зураасын урт 6 см, талыг холбосон зураас 4 см, өргөн дунджаар 0,2 см, гүн 0,1 см. Хөлөгний дүрслэлтэй уг тоосгоны хагархай 17,5 см х 24 см х 6,3 см бөгөөд мөн Хар Балгасын цайзат их хэрмийн доторх суварганы

дэргэдэх хоёр шороон овгорын өмнө талын (зүүн барилга) хойд хөвөө орчмоос буюу НВ 2 малтлагын DD 26 талбайн 85 дугаар өрөгт, малталтын 4 дүгээр үеийн гүнд В 2028 дугаар хөрснөөс олдсон. Хүндийн жин нь ойролцоогоор 2,7 кг. Олдворын дугаар: 10/08/2 буюу 1200 дугаартай болно (Зураг 1 с).

Тоглоомын хасаа

1-р хасаа. Шилээр цутгаж хийсэн, гялалзсан ногоон өнгөтэй. Дугуй хэлбэр бүхий хавтгай суурьтай, мөлгөр оройтой. Хөндлөн огтлолоороо тал дугуй хэлбэртэй. Голч нь 2,9 см, ерөнхий өндөр нь 1,2 см. Суурин хэсгийг хөвөөлүүлэн их биеэс 0,2 см өргөн, 0,3 см зузаан хүрээ гаргаж цутгасан. Хүндийн жин нь 25 гр. Уг хасааны суурин хэсгээс бага зэрэг хэлтэрч гэмтсэнээс бус үндсэндээ бүрэн бүтэн хадгалагдсан байна. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 37 талбайн 41 дүгээр өрөгт, малталтын 5 дугаар үеийн гүнд В 500 дугаар хөрснөөс олдсон, 01/09/03 буюу 6 дугаартай болно (Зураг 2 h).

2-р хасаа. Нэгдүгээрхийн ижил хийц загвартай өөр нэг хасааны хагархай. Гялалзсан шар өнгөтэй. Бүтэн хасаатай харьцуулж үзэхэд ойролцоогоор 1/2 хэсэг нь бөгөөд 1,2 x 2,8 см. Хүндийн жин 9 гр. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 37 талбайн 41 дүгээр өрөгт, малталтын 5 дугаар үеийн гүнд В 500 дугаар хөрснөөс олдсон, 01/09/02 буюу 5 дугаартай болно (Зураг 2 f).

3-р хасаа. Хийц загвараараа мөн нэгдүгээр хасааны ижил боловч хэд дахин жижигхэн юм. Гялалзсан шар өнгөтэй. Зах хөвөө нь зарим газарт эмтэрч гэмтсэн. Голч 1,4 см, өндөр 0,6 см. Хүндийн жин нь 3 гр. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 37 талбайн 36 дугаар өрөгт, малталтын 5 дугаар үеийн гүнд В 500 дугаар хөрснөөс олдсон, 01/09/04 буюу 7 дугаартай болно (Зураг 2 b).

4-р хасаа. Нэгдүгээрхийн ижил хийц загвартай. Гялалзан ногоон өнгөтэй. Голч нь 2,4 см, ерөнхий өндөр нь 1 см. Суурийн өргөн 0,2 см, зузаан 0,2 см. Хүндийн жин нь 12 гр. Уг хасааны суурин хэсгийн нэг талаас бага зэрэг эмтэрч гэмтсэнээс бус үндсэндээ бүрэн бүтэн хадгалагдсан байна. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 27 талбайн 91 дүгээр өрөгт, малталтын 4 дүгээр үеийн гүнд В 2018 дугаар хөрснөөс олдсон, 24/07/2 буюу 1058 дугаартай болно (Зураг 2 g).

5-р хасаа. Нэг ба дөрөвдүгээрхтэй ойролцоо хэлбэр хэмжээтэй. Гялалзсан ногоон өнгөтэй. Голч нь 2,2 см, ерөнхий өндөр нь 0,9 см. Суурийн өргөн 0,1 см, зузаан 0,2 см. Хүндийн жин нь 10 гр. Уг хасааны суурин хэсгийн нэг талаас бага зэрэг эмтэрч гэмтсэнээс бус үндсэндээ бүрэн бүтэн хадгалагдсан байна. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 26 талбайн 89 дүгээр өрөгт, малталтын 4 дүгээр үеийн гүнд В 2026 дугаар хөрснөөс олдсон, 29/07/8 буюу 1106 дугаартай болно (Зураг 2 i).

6-р хасаа. Хийц загвараараа өмнөхийн ижил боловч хэд дахин жижигхэн юм. Гялалзсан ногоон өнгөтэй. Зах хөвөө нь эмтэрч үгүй болсон. Голч 1 см, өндөр 0,4 см. Хүндийн жин нь 1 гр. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 26 талбайн 95

дугаар өрөгт, малталтын 5 дугаар үеийн гүнд (х: 755,968 у: 1170,132 з: 89,842) В 2018 дугаар хөрснөөс олдсон, 26/07/2 буюу 1068 дугаартай болно (Зураг 2 е).

7-р хасаа. Дээрхийн адил хэлбэр хэмжээтэй. Гялалзсан ногоон өнгөтэй. Зах хөвөө нь зарим газарт эмтэрч үгүй болсон. Хөвөөний өргөн 0,1 см, зузаан 0,1 см. Голч нь 1,4 см, ерөнхий өндөр нь 0,6 см. Хүндийн жин нь 2 гр. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 26 талбайн 79 дүгээр өрөгт, малталтын 4 дүгээр үеийн гүнд (х: 758,724 у: 1172,109 з: 89,788) В 2026 дугаар хөрснөөс олдсон, 03/08/12 буюу 1120 дугаартай болно (Зураг 2 d).

8-р хасаа. Мөн өмнөхийн ижил хэлбэр хэмжээ, хийц загвартай. Гялалзсан шар өнгөтэй. Суурин хэсгийг хөвөөлүүлэн их биеэс 0,1 см өргөн, 0,1 см зузаан хүрээ гаргаж цутгасан. Голч нь 1,5 см, ерөнхий өндөр нь 0,7 см. Хүндийн жин нь 3 гр. Суурийн нэг талаас бага зэрэг хэлтэрч гэмтсэн байна. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 26 талбайн 89 дүгээр өрөгт, малталтын 4 дүгээр үеийн гүнд В 2026 дугаар хөрснөөс олдсон, 28/07/18 буюу 1084 дугаартай болно (Зураг 2 а).

9-р хасаа. Дээрхийн ижил хийц загвартай. Гялалзсан ногоон өнгөтэй. Уг хасааны суурин хэсгээс бага зэрэг хэлтэрч гэмтсэнээс бус үндсэндээ бүрэн бүтэн хадгалагдсан байна. Суурийн өргөн 0,2 см, зузаан 0,2 см. Голч нь 1,5 см, ерөнхий өндөр нь 0,7 см. Хүндийн жин нь 4 гр. Олдворын дугаар: өмнөхтэй хамт олдсон болно (Зураг 2 с).

Сийлбэртэй шагай

Богийн шагайн хонь буух тал дээр өнцгүүд болон талуудыг хооронд нь шулуун зураасаар холбосон, дотор дотроо орсон дөрвөн нүднээс бүрдэх дүрс тэмдгийг нарийн үзүүртэй зүйлээр сараачиж гаргасан байх бөгөөд бусад талд нь ямар нэгэн хээ чимэг болон зассан шинж тэмдэг байхгүй. Хүндийн жин нь 6 гр. Элэгдэлд орж зарим газарт хэлтэрснээс бус үндсэндээ бүрэн бүтэн хадгалагдсан байна. Олдворын дугаар: НВ 2 малтлагын DD 22 талбайн 88 дугаар өрөгт, газрын өнгөн хөрснөөс 150 орчим см гүнд буюу малталтын 9 дүгээр үеийн гүнд В 2001 дүгээр хөрснөөс олдсон болно. Олдворын дугаар: 22/07/16 буюу 1024 дугаартай болно (Зураг 1 d).

Монголчуудын оюуны соёлын нэгэн хэсэг болсон ардын баяр цэнгэл, тоглоом наадмын зүйл дотор хүний оюун ухааныг хөгжүүлэн, ухаан бодлыг нь тэлж өгдөг хөлөгт тоглоом чухал суурь эзэлнэ. Монгол нутагт байсан эрт, дундад үеийн нүүдэлчид дэлхийн соёлт бусад ард түмний нэгэн адил олон төрлийн хөлөгт тоглоомоор наадаж байсны гэрч баримт археологийн судалгааны явцад илэрч олдсон байдаг (Амарбилэг, Эрдэнэбат 2009). Угсаатны зүйн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд түүхийн аль ч үед хүмүүс гарын дор бэлэн олдох элс шороо, хад чулуу, ширээний тавцан, замын хавтан дээр ч юмуу өрөг сараачин зураад аль тохиромжтой чулуу, мод, яс (шагай), мал амьтны аргал хорголоор хүртэл хасаа болгон наадаж байжээ. Хүний оюуны болон материаллаг хэрэгцээ

хязгааргүй өсөн нэмэгдэхийн хирээр тоглоомын хөлөг, хасааг тусгайлан хийх болж үүнийг үйлдэх арга хэлбэр, эд материалын төрөл зүйл ч нэн арвижсан байна. Харин эрт дээр үеийн хүмүүсийн тоглоом наадмын зүйл олон зуун жилийн турш хадгалагдаж бидний үеийг хүрч ирэх нь нэн ховор байдаг байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулсан археологийн судалгаагаар илэрч олдсон, түүхийн олон үед холбогдох хөлөгт тоглоомын олдворыг үзэхэд, Хар Балгас болон Хархорумаас цөөнгүй олддог уран гоёмсог шилэн хасаанаас гадна, бас хүн төрөлхтний нийтлэг жишгийн адил, ихэвчлэн гарын дор элбэг олдох энгийн материалаар юмуу эсвэл нэгэнт анхдагч хэрэглээнээсээ гарч хаягдмал болсон эд зүйлийг ашиглан, тухайлбал, байгалийн бэлэн чулуу (Ерөөл-Эрдэнэ 2007: 281; Очир нар 2008: 61), шавар (Цэвээндорж, Эрдэнэбат 2006: 61; Эрдэнэбат, Батбаяр 2008), ваар, шаазан сав суулганы хагархай (Pohl 2010: 168, Cat-Nr. 28-51), барилга байшингийн дээврийн ваарны хэлтэрхий (Pohl 2010: 170, Cat-Nr. 52-58) зэргийг засаж янзлан хасаа хийж тоглож байсан биет баримт олдсон ажээ.

Манай оронд урьд өмнө хийсэн эртний судлалын малтлагаар, хөлөгт тоглоомын хасаа төдийгүй түүхийн олон янзын эрин үед холбогдох хоёр ч өөр төрлийн хөлөгт тоглоомын хөлгийн үлдэгдэл биет байдлаараа олдсон юм. Эдгээрээс он цагийн хувьд, Архангай аймгийн Хайрхан сумын нутаг Гол модны хүннүгийн язгууртны оршуулгын газрын 1-р булшнаас гурван ширхэг хасааны хамт олдсон, модон дээр сийлж урласан хөлгийг одоогоор бидэнд мэдэгдэж буй энэ төрлийн хөлөгт тоглоомын хамгийн эртний хувилбарын нэг хэмээн үзэж болно.

Хүннүгийн хөлөгт тоглоомын олдвор илэрсэн Гол модны 1-р булшны насыг орчин үеийн байгалийн шинжлэх ухааны лабораторийн шинжилгээ болон уг оршуулганд дагалдуулсан хүрэл толиор МЭ 20-50 он хэмээн нарийн тогтоожээ. Энэхүү олдворын тухай өгүүлэл бичсэн судлаач Ч. Ерөөл-Эрдэнэ тухайн үед үүнтэй шууд адилтгах хэрэглэгдэхүүн олж хараахан чадаагүй боловч хийцийн хувьд “шианчи” хэмээх хятад шатартай ойролцоо байна, түүнчлэн энэ булшнаас морин тэрэг, хүрэл толь, хүрэл сав суулга зэрэг хятад хийцийн эд зүйлс арвин гарсан тул энэхүү хөлөгт тоглоом ч мөн адил Хан гүрнээс Хүннүд илгээсэн зүйл байхыг үгүйсгэх аргагүй гэж дүгнэсэн байдаг (Ерөөл-Эрдэнэ 2007: 284). Гэвч бидний санахад Гол модны хөлөгт тоглоомын өрөг зохион байгуулалтаараа өмнө зүгийн Хятадын хөлөгт тоглоомоос, тухайлбал “шианчи” хэмээх шатраас огт өөр бөгөөд харин өрнө зүгээс буюу Энэтхэг, Персээс үүсэж дундад зууны үед иран хэлт согд худалдаачдаар дамжин Төв Азид дэлгэрсэн нэгэн зүйлийн шатартай илүү төстэй хувилбар бололтой байна.

Гол модны хүннү булшнаас олдсон тоглоомын хөлгийн үлдэгдэлд модон тавцангийн дээр сийлсэн тус бүр 4,5 х 6,8 см хэмжээтэй 12 х 4 нүд хадгалагдсан байх ба уг хөлгийн нүдэнд тусах хамгийн онцлог зүйл бол дунд нь нэг нүд

үлдээж, түүний хоёр хажуугийн нүдэнд “Х” хэлбэрийн хэрчлээс гарган тэдгээрийн хажуу талд мөн хоёр нүд сул үлдээгээд дараагийн нүдэнд мөн “Х” хэлбэрийн хэрээс гаргасан зохиомжтой байгаа юм (Зураг 3 а). Энэ онцлог байдал нь эртний “caturanga” шатраас гаралтай Энэтхэгийн “ashtapada” (Зураг 3 б) хэмээх тоглоомын хөлөгтэй төстэй байна (Eder 2003: 2). Саяхан болтол энэ төрлийн хөлөгт тоглоомын биет олдворын хамгийн эртнийх хэмээн Согдын баруун хот Пайкенд (одоогийн Узбекистан улсын Бухара хотоос баруун урагш 60 км орчим зайтай оршино) дахь нэгэн цитадельд хийсэн малтлагаас олдсон хөлгийг тооцож байлаа. Стратиграфийн шинжилгээгээр түүний он цагийг IV зууны хоёрдугаар хагас, V зууны эхэн үе гэж тогтоосон байдаг. Тоглоомыг өргийг трапец хэлбэртэй (21 x 27 x 48 см) тоосгон дээр сараачиж зурсан бөгөөд энэ бол цитаделийг барихад барилгын материал болгон ашиглаж байсны ижил ердийн нэгэн шатаасан тоосго юм (Зураг 3 с). Тоосгоны хавтгай нүүрэн талын төв хэсэгт шатаахаас өмнө шавар дээр хуруугаараа дарж гаргасан хэрээс (тоонолжин) бол тоосго шатаасан хүний урлангийн тэмдэг ажээ. Шатаасны дараа гурван эгнээ, дунд эгнээ нь нөгөө хоёроосоо ялигүй өргөн, тус бүр найман нүдтэй өргийг сараачин зурж дүрсэлжээ. Түүнээс гадна дунд эгнээний захаасаа гурав дахь хоёр нүдийг огтлолцсон диагональ шугамаар хэрээс гаргаж сийлсэн байна (Semenov 1996: 16, Abb. 3, 4.1).

Гол модны булшнаас олдсон хүннүгийн хөлөгт тоглоомын хөлөг Пайкандын тоосгон хавтан дээр зурсан хамгийн эртнийх гэж үзэж байсан хөлгөөс даруй 300 гаруй жилээр ахмад настай байгаа юм. Хэрэв энэ баримтыг үндэслэвэл хүннү нар Дундад Азиас өмнө энэ төрлийн хөлөгт тоглоомыг мэддэг байсан, согдууд энэ тоглоомыг Хүннүгээс ч уламжилж авсан байж болох юм. Ганц энэ жишээ л гэхэд Монголын хүннү нарын төдийгүй ер нь нийт нүүдэлчдийн соёлын асуудлыг судлахдаа олон өнцгөөс харах шаардлагатайг харуулж байна.

Манай улсын нутгаас олдсон өөр нэг хөлөгт тоглоомын олдвор бол үүнээс нэлээд хожуу үед хамаарна. Уг олдвор 1948-1949 онд Хархорум хотын турьд археологийн дорвитой малталт хийсэн Монгол-Зөвлөлтийн түүх угсаатны зүйн шинжилгээний ангийн судалгаагаар их хотын зүүн хаалганы орчмоос илэрчээ. Энэ хөлгийг тусгайлан үйлдсэн шавар тавцан дээр зурж хийсэн бөгөөд монголчуудын хуучны буга тоглоомтой адилхан байсан гэж судлаачид үзсэн байна (Евтюхова 1965: 294-295).

Тэгвэл бидний өгүүлж буй, Уйгурын Хар Балгасаас олдсон хөлөгт тоглоомын биет олдворууд нь манай оронд археологийн малталт судалгаагаар илэрч буй эртний хөлөгт тоглоомын хөлгийн гурав дахь нь болж байна. Үүний хамт чинад нууц нандин бэлгэ тэмдэг агуулсан энэ тоглоом хаанаас гаралтай, түүнийг хэрхэн яаж тоглож байсан, ямар учир бэлгэдэлтэй, хэрэв харь газраас ирсэн бол хэзээ, ямар замаар Монгол нутагт дэлгэрсэн байж болох, энэ нь хожмын монгол угсаатны оюуны соёлд ямар учир холбогдолтой болох зэрэг сонирхолтой олон асуулт тавигдах нь зүйн хэрэг билээ.

Хар Балгасын энэхүү олдворын үүрэг зориулалтыг үнэн зөв тодорхойлж хэзээ хаана үүсэж хаашаа ямар газар орон, аймаг угсаатны дунд түгэн тархсан байдлыг ойлгоход чухал харьцуулах хэрэглэгдэхүүн бол дундад зууны үед өрнө зүгт дэлгэрсэн хөлөгт тоглоомууд болно. Эдгээрийн дотроос, өрнөдийн судалгааны ном зохиолд англиар “*Nine Men’s Morris*”, “*Twelve Men’s Morris*” хэмээн бичдэг нэгэн зүйлийн хөлөгт тоглоомын хувилбар манай олдвортой ижилхэн байгаа юм (Зураг 4).

Уг тоглоомын өрнө зүгт тархсан хувилбарын нэрийг судлаачид тайлбарлахдаа, *Morris* гэдэг нь латин хэлний “*merellus*” хэмээх үгээс гаралтай бөгөөд тоглоомын хасаа, мөн эсрэг тал гэсэн утгатай гэжээ (Содномжамц, Эрдэнэбат 2010 : 99). Энэхүү тоглоом анх эртний соёлт Египет оронд үүсч, улмаар Африк, Европ, Азийн олон оронд түгэн дэлгэрсэн, тэгэхдээ тухайн газар нутгийнхаа улс түмний соёлын онцлогоос хамаарч өөр өөр нэртэй болсон түүхтэй юм байна. Тухайлбал, Өмнөд Африкт *Morabaraba*, Энэтхэгт *Naukhadi*, Францад *Jeu de Moulin*, Италид *Mulino*, Германд *Muehlespiel*, Орос оронд *мельница*, дундад зууны Ром, Византын үед *Nine Men’s Morris*, Сомалийн арлуудад *Shax* гэж нэрлэгдэж байсан ажээ (Berger 2004: 16). Энэхүү тоглоомын хөлгийн харилцан адилгүй цаг үед бүтээгдсэн дүрс тэмдгүүд дээрх олон газар орны өөр өөр дурсгалт газраас хадны сүг зураг, сүмийн хана туурга, торгон нэхмэлийн зураг, булшны чулуу, сандал ширээ, хөлөг онгоцны тавцан зэрэгт сийлсэн байдлаар, мөн жинхэнэ тоглоомын хөлөг байдлаар ч эртний хот суурин ба булш оршуулгын аль алинаас нь олдож байжээ.

Хятадын археологичдын хийсэн судалгааны материалд үзэхэд, Хар Балгасын хөлөгт тоглоомынхтой яг ижилхэн, тоосгон хавтан дээр сийлсэн хөлгийн олдвор 2010 оны 10 сард Өвөр Монголын өөртөө засах орны Баарин зүүн хошууны нутагт Киданы Ляо (907-1125) улсын Тайзу Елюй Абаожи (872-926) хааны бунханы цэцэрлэгт хүрээлэнгийн 4 дүгээр барилгын суурийн баруун хэсгийг малтахад нэг ширхэг олдсон ажээ (Heilongmen gate 2011: 170). Энэ нь одоогоор БНХАУ-ын нутгаас илэрсэн хөлөгт тоглоомын олдворын дотор Хар Балгасынхтай харьцуулж болохоор, одоогоор бидэнд мэдэгдэж буй цорын ганц харьцуулах хэрэглэгдэхүүн болж буйн зэрэгцээ, *нэгдүгээрт*, Уйгурын Хар Балгасаас хожуу цаг үеийнх, *хоёрдугаарт*, нүүдэлчдийн үлдээсэн соёлын дурсгал байгаагаараа анхаарал татаж байна (Зураг 5 а).

Дорнод Европын орнуудад малтан шинжилсэн дундад зууны үеийн зарим хот суурингийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд, манай Хар Балгасаас олдсон тоглоомын хөлгийн өрөгтэй төстэй болон бүр яг адилхан дүрс тэмдэгтэй тоосго, тоглоомын хөлгүүд нэг бус удаа биет байдлаар олдсон баримт байна. Тухайлбал, одоогийн ОХУ-ын өмнөд хэсэгт орших Дон мөрний эрэг дээрхи, зүүн Европт Ижил мөрнөөс Днепр, Крымээс хойд Кавказ хүртэлх өргөн уудам нутгийг VII-X зууны үед эзэмшилдээ авч төр улсаа байгуулж явсан Хазарын хаант улсын нэгэн чухал

төв байсан цайзат их хэрэм бүхий Саркел (МЭ 834-965) буюу хазаруудын нэрлэж байснаар “Цагаан байшин” гэдэг хотын малтлагаас элдэв янзын зурлага, мал амьтан, хүний дүрс болон тамга тэмдэгтэй хэдэн зуун шавар тоосго олджээ (Артамонов 1958: 23-27, рис. 13; Щербак 1959: 367, табл. XXIV). Түүний дотор, өнцөг болон талуудыг хооронд нь шулуун ба ташуу зураасаар холбосон дотор дотроо орсон дөрвөн нүднээс бүрдэх сонин дүрс тэмдэгтэй бүтэн хадгалагдсан хавтан тоосго, мөн зөвхөн тал хооронд нь шулуун шугамаар холбосон дотор дотроо орсон гурван нүд бүхий тэмдэг гэсэн хоёр үндсэн хувилбар, нэмэлт дүрс тэмдгүүд байгаа нь Орхоны Хар Балгасаас олдсон тоосгон дээр сараачсан дүрстэй ялгарах зүйлгүй ижил юм. Византийн уран дархчуудын оролцоотой барьж байгуулсан уг хотоос олдсон тэмдэг дүрс, Хар Балгасын хөлөгт тоглоомын өрөг дээрх тэмдэг дүрсийн аль алийг нь шавар тоосгон дээр ижилхэн арга барилаар дүрсэлсэн нь сонирхолтой (Зураг 6).

Үүнээс гадна Хар Балгасын хөлөгт тоглоомын тавцан дээрхтэй ижил төстэй дүрс тэмдгүүд Египетэд МЭӨ 1400-1350 оны үед хамаарах сүмийн дээвэр (Murray 1978: 18-19, 44), Сирид 106-634 оны хоорондох барилгын хана (Berger 1999: 23), Швейцар (Schwegler 1992: 85), Шри Ланкад I зууны орчимд холбогдох хадны зурагт, Ирландад чулуун зэвсэг болон хүрлийн үед хамаарах булшнаас олдсон хавтан чулуун дээр, Турк улсын нутагт III-IV зууны христос шашинтны булшнаас гарсан барилгын хавтан дээр (Berger 2004: 15), Германд Ромын эзэнт гүрний үеийн сүмийн сэнтийн дээр (Mandl 1994: 44-65), дундад зууны хожуу үеийн барилгын ханын чимэгт (Berger 1996: 17-32), Хотан газар VI зууны үед зурсан Бурхан багшийн хөрөгт (Bussagli 1963: 55), Дорнод Туркестаны Кучад VII зууны сүмийн дээвэрт (Bussagli 1963: 86), X зууны үеийн Дундад Азийн согд торгоны хээнд (Belenizki 1980: 23), Орост XII-XIII зууны тоглоомын хөлөг (Рыбина 1997: 111, Таб. 79: 15-17), Энэтхэгт XIV-XVI зууны үед хамаарах Хиндугийн дурсгалт газар хаданд сийлсэн (Rogersdotter 2010: 287-291, Fig. 4), Чех улсын нутагт нэлээд хожуу үед холбогдох чулуун хавтан дээр цоолборлосон (Wollenk 1991: 11-20) зэрэг байдлаар олдсон баримт өдий төдий байна (Зураг 7-8).

Ийм дүрс бүхий дурсгал олдсон газрын байршлыг ажиглахад, олон янзын соёлууд уусан нийлсэн чухал чухал уулзвар газруудад төвлөрч байхын зэрэгцээ эдгээр бэлгэ тэмдгийн нэлээд хэсэг нь хөлөгт тоглоомын өрөг болгон ашиглах ямар ч боломжгүй байшин барилгын тааз, хана туурга, хад зэрэг босоо гадаргуу дээр дүрслэгдсэн байгаа нь эрхгүй анхаарал татна. Энэ байдлаас үндэслэж зарим судлаачид энэ дүрс тэмдгийг зөвхөн хөлөгт тоглоомын өрөг төдий зүйл бус, цаанаа нандин утга агуулгатай, далдын ид шидийн хүчнийг бэлгэдсэн хэмээн тайлбарлаж байна.

Уг дүрсийг түүхийн өөр өөр цаг үед янз бүрийн зүйл дээр дүрсэлж байсан, зориулалт нь ч бас харилцан адилгүй байгаа боловч хөлөгт тоглоомын үүрэг гүйцэтгэж байсан олдворуудыг бүлэглэн авч үзвэл бүгдээрээ нэгэн ижил дүрмээр

тоглодог байснаараа адил болох ажээ. Эдгээрийн холбогдох он цагийг тодорхойлсон байдлаас үзэхэд, хамгийн эртнийх нь Египетэд МЭӨ 1400-1300 оны үеийн Курна хэмээх сүмийн хананд, Византид V-XI зууны Секун гэдэг газар, хамгийн хожуу үеийнх нь XII зууны Нормандын нэгэн цайзаас олдсон хөлөг болж байна. Мөн Оросын Новгород хотын орчим малтсан дурсгалаас олдсон модон тавцан дээр дүрсэлсэн хөлөг XII-XIV зууны үед холбогдоно гэж судлаачид үзжээ (Содномжамц, Эрдэнэбат 2010: 95). Иймээс энэ төрлийн хөлөгт тоглоом Африк тивд нэн эрт цагт үүсч, Өрнөд Азиар дамжин Европт, улмаар тэндээсээ Дундад Азиас Төв Ази руу дэлгэрэхдээ маш урт удаан хугацааг даван туулсан байна.

Эдгээр баримтаас дүгнэж үзэхэд, бидний сонирхон бүхий энэхүү тоглоомын хөлөг болон түүнтэй хамт олдсон хоёр янзын хэмжээ ба өнгөтэй хасаа зэргийг цогцоор нь өрнө дахинд ихэд дэлгэрч хөгжсөн дурдсан тоглоомын эх хэрэглэгдэхүүнтэй харьцуулан шинжилж түүнийг хэрхэн яаж тоглож байсан дүрмийг үнэн зөвөөр нэхэн сэргээх бүрэн боломж байна. Үүний тул өрнөдөд өнөөг хүртэл тоглож буй, англиар “*Nine Men's Morris*” буюу “*Twelve Men's Morris*” хэмээдэг тэрхүү тоглоомын хөлөг хийгээд тоглох дүрэм зэргийн талаар шатрын түүхийг тусгайлан судалсан Английн эрдэмтэн H.J.R. Murray гэдэг хүний бүтээлд түшиглэж авч үзье.

Тэрбээр уг тоглоомын тоглох дүрмийг тухай: ”9 хасаагаар тоглодгий нь *Nine Mens Morris*, 12 хасаагаар тоглодгий нь *Twelve Mens Morris* гэж нэрлэх бөгөөд эдгээрийг тоглох дүрэм ижилхэн юм. Эдгээрийг хоёр хүн тоглох ба тоглогчид ээлж дараалан тус тусын хасаагаар нүүнэ. Тоглоом эхлэхдээ хоосон хөлгийн тавцангаас эхлэх бөгөөд өөрт буй хасаануудаа тавцангийн хөндлөн болон диагональдсан шугаманд байх огтлолцсон хэсэгт (ортогонал шугамаар) дараалан гурав гурваар байрлуулахыг¹ эрмэлзэж тоглодог юм. Ингэж гурвыг зэрэгцүүлэн тавьсан тохиолдолд өрсөлдөгчөөсөө дуртай нэг хасаагаа идэж болно. Харин нэг шугаманд байрлуулсан 3 хасаанаас авч болохгүй юм. Энэ мэтчилэн гарт буй хасаагаа бүгдийг хөлөг дээр байрлуулсны дараа тоглоомын эхний үе дуусч дараагийн үед хөлгийн аль нэг хэсэгт үлдсэн сул буудал руу нүүж тоглоно. Ингэж тоглосоор байтал аль нэг тоглогчид гурван хасаа үлдвэл заавал зураасны дагуу нүүхгүй буудал алгасч дурын буудалд нүүх эрхтэй болдог. Хэрвээ эсрэг тоглогч нь нүүх боломжгүй гацаанд орох юм уу аль эсвэл хасаа нь хоёр болсон тохиолдолд тоглолт дуусах болно” (Murray 1978: 46) хэмээн тодорхойлон бичжээ.

Ийнхүү Хар Балгасаас олдсон хөлгийг дундад зууны үед өрнө зүгт дэлгэрсэн ижил төрлийн хөлөгт тоглоомын дүрэмтэй харьцуулан шинжилснээр эртний Уйгуруудын утга соёлын нэгэн чухал баримт болох энэхүү хөлөгт тоглоомыг хэрхэн тоглож байсныг нэлээд тодруулах боломж бүрдэж байна. Бидний санахад, Хар Балгасын хөлөгт тоглоомыг ерөнхийдөө дээр өгүүлсэн

¹Ингэж нэг шугаманд гурван хасаа байрлуулахыг өрнөдөд “mill” боллоо гэж хэлдэг бол монголчууд “жиргэх” гэж хэлдэг тусгай нэр томъёотой байна.


дүрмээр тоглодог байсан мэт боловч тоглох хасааны хувьд өрнөдийнхөөс бага зэрэг онцлог ялгаатай байгаа юм. Үүнд, өрнөдөд тархсан энэ төрлийн тоглоомыг ихэнхдээ ижил хэмжээтэй хоёр өөр өнгийн хасаагаар тоглодог бол харин Хар Балгасын хөлгөөр наадагсад том жижиг арван хоёр ногоон, арван хоёр шар хасаагаар тоглож байсан нь археологийн олдворын цогц байдлаас мэдэгдэж байна. Энэхүү ялгаа нь манай хэрэглэгдэхүүн дотроо илүү нарийн дүрмээр тоглодог байсныг харуулах баримт бололтой.

Уг хөлөгт тоглоомыг тоглож сурахад хялбар төдийгүй тоглоомын тавцанг хийхэд маш энгийн боловч тоглож буй хүнээс нэлээд ухаан шавхсан, цэвэр стратегийн тоглоом гэж үзэж болно. Тиймээс ийм тоглоомыг нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүс түүхэн хөгжлийн олон үед тоглож байжээ. Хасааны нэрийн хувьд, Африкт үхэр юм уу үнээ, Дундад Азийн улс орнуудад хүн, морь, чулуу, хоргол, гэхдээ ихэвчлэн хасаа гэж нэрийдэж байсан байна.

Хар Балгасаас олдсон тоглоомын хөлөг дээрх дүрстэй ижил дүрсийг өрнийн судлаачид хөлөгт тоглоомоос гадна христос, лалын шашинтай холбоотой шашин мөргөлийн зан үйлийн бэлгэ тэмдэг хэмээн тайлбарласан байдаг. Уг дүрс тэмдгийг шашны ёслолын ариун газар дүрслэх бөгөөд ингэснээр хүмүүс дэлхийн энергитэй оюун санааныхаа далд түвшинд холбогдож төгс болно гэж үзэхээс гадна үүнийг зурснаар тухайн хүн далдын ид шидэнд автаж аз авчирч улмаар айдас хүйдэс, муу ёрын хүчнээс хамгаалдаг хэмээн бэлгэддэг байна. Үүнээс гадна хүн төрөлхтөн ёс зүйн зөв замаас гажилгүй түүний зөв замыг дагаж явна гэж үздэгээрээ манихейн шашинтай мөн холбогддог аж². Эдгээрийн бодит жишээ бол өмнө дурдсан эртний Египет, Ром, Сири, Дорнод Туркестан зэрэг газрын шашны холбогдолт уран барилга, дүрслэх урлагийн дурсгалуудад цөөнгүй тохиолдож байгаа дүрслэл юм.

Монгол орны нутаг дэвсгэрээс шинээр олдсон энэхүү тоглоомын хөлөг дээрх дүрс нь нөгөө талаар хилийн чанад дахь улс орнуудын түүхэн дурсгал дээрх ижил хэлбэрийн дүрслэлтэй утга агуулга ойролцоо, шашин шүтлэгийн зан үйлтэй холбоотой өвөрмөц нэгэн бэлгэ тэмдэг гэж үзэх бүрэн үндэс буй. Учир нь Хар Балгасаас холгүй орших Өвөр хавцалын ам хэмээх газарт буй VIII-IX зууны үеийн Уйгурын бунхант булшнаас яг ийм дүрс тэмдэгтэй тоосгоны хагархай бас олдсон нь энэхүү дүрс тэмдэг үнэхээр оршуулга болон тахилгын зан үйлийн утга агуулга илэрхийлж байсан байж магадгүйг хэлж өгч байна. Архангай аймгийн Хотонт сумын нутаг Өвөр хавцалын амны 5-р дөрвөлжингөөс малтаж гаргасан уг олдворыг судлаачид тодорхойлсон байдлаас үзэхэд, энэ нь 30 см х 31,5 см хэмжээтэй шатаасан хөх өнгийн хавтан тоосго бөгөөд таван хэсэг болж хагарсан байжээ (Очир нар 2010). Эдүгээ Монголын Үндэсний Музейн сан хөмрөгт

²http://en.wikipedia.org/wiki/Nine_Men%27s_Morris

хадгалагдаж байгаа энэхүү олдворыг үзэхэд нүүрэн талд нь  - дүрс тэмдгийг сараачиж гаргасан нь тодорхой мэдэгдэж байна (Зураг 5 б).

Энэ бүхнээс үзэхэд, энэхүү хөлөгт тоглоом Африк тивд анх үүсч, Өрнөд Азиар дамжин Европт, улмаар тэндээсээ Дундад Азиас Төв Ази руу тархаж, Монгол газар анх уйгуруудын дунд дэлгэрсэн бололтой. Энэхүү тоглоомын олдворыг эртний болон дундад зууны үед Хятад газар дэлгэрсэн хөлөгт тоглоомуудтой харьцуулан үзэхэд хийц загвар, тоглоомын дүрмийн хувьд эрс ялгаатай юм. Бидний бодоход, уйгурууд тухайн үедээ зөвхөн Хятад төдийгүй Дундад Азийн өндөр соёлт Согд нартай улс төр, эдийн засаг, соёлын талаар өргөн харилцаж Манихейн шашинг төрийн шашин болгон дэлгэрүүлж явсан тул түүхийн энэхүү дэвсгэр дээр авч үзвэл, уг тоглоом Монгол газар анх түгэн дэлгэрэхдээ Хятадаас бус, харин баруун зүгээс Согдуудаар дамжин орж ирсэн байх бололцоо нь илүү мэт санагдана. Учир нь, уйгурууд VIII-IX зууны үед ид хүчирхэг байхдаа торгоны замын хэсэг газрыг нэгэн үе өөрийн хяналтанд байлгаж алба татвар авч байсан, хоёрдугаарт, Манихейн шашинд Хар Балгасаас олдсон энэхүү олдвор дээрх дүрслэлтэй яг ижил тэмдэг дүрсийг бэлгэ тэмдэг болгож байсан, гуравдугаарт, энэхүү бэлгэ тэмдэг тухайн үеийн Согдын хэд хэдэн биет хэрэглэгдэхүүн болон торгоны замд орших дурсгалаас илэрч мэдэгдсэн зэрэг баримтууд мэдэгдэж байгаа юм. Тухайлбал, VII-VIII зууны үеийн Согдын Пенжикент хотын орчмоос олдсон булшны хөшөө чулуу (Berger 2004: 22-23), Дорнод Туркестаны Куча дахь VII зууны нэгэн сүмийн дээврийн чимэглэл зураг (Bussagli 1963: 86), X зууны үеийн Дундад Азийн согд торго (Belenizki 1980: 230) зэрэг Торгон зам ба Согдын соёлтой холбоо бүхий эд өлгийн дурсгалуудад ийм бэлгэ тэмдэг олонтаа үзэгдэж байна (Зураг 9).

Угсаатан судлалын баримт, судалгааны ном зохиолоос үзэхэд, одоогоор бидэнд олдож буй Хар Балгасын биет олдворыг эш үндэс болговол лавтайяа VIII-IX зууны үеэс Монгол газар нэвтрэн дэлгэрсэн энэ төрлийн хөлөгт тоглоом хожмын монголчуудын тоглоом наадмын соёлд байр сууриа олж монгол үндэстний нэгэн зүйлийн тоглоом болж хөгжсөн ажээ. Энэхүү тоглоомыг монголчууд нутаг нутагт хэд хэдэн янзаар нэрлэх боловч “жиргээ” хэмээх нэр бол хамгийн түгээмэл нэр байсан байна.

Өрнөдөд *Twelve mens Morris* хэмээн нэрлэж буй тоглоомын хөлөгтэй яг ижилхэн монгол хөлөгт тоглоомын зургийг Монголчуудын хөлөгт тоглоомыг олон жил тусгайлан судалсан судлаач Н. Намжилдорж 1966 онд хэвлүүлсэн “Монголын хөлөгт тоглоом” гэдэг бүтээлдээ нийтэлсэн байдаг. Тэрбээр, монголчууд XIII зууны үед “Хонин шатар” хэмээх нэгэн зүйлийн хөлөгт тоглоом тоглож байсныг дурдаад, манай Хар Балгасын олдвортой яг ижил хөлгийн зургийг хавсаргаж, хэрхэн яаж тоглодог дүрмийнх нь талаар дэлгэрэнгүй тайлбарлан бичсэний зэрэгцээ үүнтэй ойролцоо хөлөг өрөг бүхий, мөн ижил дүрмээр тоглодог олбог, эсгий үүд, алтан хараацай, гургалдай, таван тал, давхар жиргэ, жиргэмэл

(Зураг 10) зэрэг өөр хувилбаруудын тухай ч дурдсан байна (Намжилдорж 1966: 23, 60, 70, 81, 97, 99, 280). Монголчуудын дунд өргөн тархсан эдгээр тоглоомын дүрмээс үзэхэд, өрсөлдөгчийнхөө нүүдлийг хаах, эсвэл хасаагаа нэг дор өрсөн байрлуулахыг *жиргэх* гэж хэлдэг бөгөөд энэ нь өрнөдийнхний mill хийх гэдэгтэй утга өөрцгүй, шулуун болон диагональдсан зураасанд өөрийн 3 хасаагаа байрлуулахыг ингэж хэлдэг байна. Иймээс энэ онцлог байдлыг үндэслэн, Монголын төв нутаг Орхоны Хар Балгасаас олдсон, улмаар хожмын монголчуудын дунд уламжлагдан дэлгэрсэн энэхүү хөлөгт тоглоомыг “жиргээ” хэмээх уламжлалт монгол нэрээр нь нэрийдэхэд болох юм гэж үзэж байна.

Ер нь хүний оюун ухааны чадавхийг хөгжүүлэхэд онц ач тустай, эртний энэ тоглоомыг өнөө үеийн хүүхэд залуучуудын дунд дахин сэргээж дэлгэрүүлсэн ч болохгүй газар үгүй билээ. Судлаач Намжилдорж гуай, хөлөгт тоглоомоор наадахын ач холбогдлын тухай: “хүүхдийн наадах, тоглох явдал бол тэдний төрөлхийн авьяас чанар мөн. Хүүхдийн төрөлхийн сайхан авьяас чанарыг боловсон тоглоомоор хөгжүүлэн хөтөлж сурлага, хөдөлмөрийн талбар өөд тэднийг үргэлжид удирдах хэрэгтэй. Ялангуяа хүүхдийн хөлөгт тоглоомыг цэцэрлэгийн дунд, ахлах ангийн насны хүүхэд, бага сургуулийн сурагчдад эрэмбэ дараатай эзэмшүүлэхэд тоо гэх мэт хичээлийн үр дүн сайжирч хүүхэд тоглож байх үедээ байгаль нийгэмтэй харилцах арга дадлага чадварыг олж сурч боловсорно” хэмээн зөв зүйтэй тэмдэглэн бичсэн байдаг (Намжилдорж 1966: 230).

Энэ тоглоомыг тоглоход ямар ч сөрөг муу юм байхгүй бөгөөд харин ч хүний оюун ухааныг дайчлах, богино хугацаанд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх гүн сэтгэлгийг хөгжүүлэх, уран шийдэл, гүйлгээ ухааныг бусад тоглоомоос илүүтэйгээр шаардах юм.

Дорно дахины ном судруудад хөлөгт тоглоомоор тоглоно гэдэг бол нэг ёсны тулалдах урлаг юм хэмээн тодорхойлсон байдаг. Монгол ардын зүйр цэцэн үгэнд ч гэсэн шатар тоглохыг “усгүй талд хүнсгүй цэрэг цусгүй байлдана” гэж хэлдэг. Учир нь тоглогч хүн түрүүлж хэдэн нүүдлийн цаадах аюулыг олж харах, эсрэг этгээдийн санааг урьдчилан таних, отох улмаар хөлгийн тавцанг эзлэх зэрэг цэвэр стратеги учир тоглоомд олсон мэдлэгээ дээр үеийн хүмүүс дайн тулаанд өргөн ашиглаж байжээ. Тийм ч учраас дорно дахины улс орнуудад хөлөгт тоглоомын авьяас чадварыг эрхэмлэн үзэж, бичиг цэргийн түшмэдийн мэдвэл зохих гол шалгуурын нэг болгож байсан билээ.

Орчин үед, хөгжингүй буурай аль ч улс оронд ялгаагүй, ялангуяа хот суурин газрын хүүхэд залуус уламжлалт соёлынхоо олон үнэт зүйлсийг мартаж байгаагийн нэг жишээг тоглоомон дээр авч үзэж болох юм. Сүүлийн үед Монголын хүүхэд, өсвөр үеийнхэн ардын уламжлалт тоглоомоо мартагнаж техник технологийн хөгжлөө дагаж компьютер тоглоомыг ихэд шохоорхон тоглож, зарим нь хэтрүүлснээс донтох зэрэг олиггүй үр дагавар гарч байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр их ярих болжээ. Хамгийн гол нь улс үндэстнийхээ түүх соёл, өв

уламжлалаа мартаж, ардын маань олон сайхан тоглоом наадам, түүний дотор уламжлалт хөлөгт тоглоомын зүйлүүд мөхлийн ирмэгт тулаад буй нь харамсалтай юм. Хүмүүсээс Та шатар, даамнаас өөр ардын ямар уламжлалт хөлөгт тоглоом мэдэх вэ? Мэддэг бол хамгийн сүүлд хэзээ тоглосон бэ? гэсэн хоёрхон асуулт тавьж үзэхэд ихэнх нь огт мэдэхгүй, энэ талаар ямар ч ойлголтгүй гэж хариулж байна. Иймд энэ мэт хуучны тоглоомын хөлгийн зураг болон дүрмийн талаарх мэдээллийг өдөр тутмын сонин сэтгүүл болон интернетэд тавьж таниулж дэлгэрүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, “жиргээ” мэтийн эртний тоглоомыг тоглож сурахад хялбар, хийж үйлдэхэд энгийн гарын дорхи материалыг ашиглан амархан хийж болох, хөлгийг нь цаасан дээр ч зураад тоглож болох учир ямар нэгэн бэрхшээл гарахгүй юм.

Ийнхүү археологийн малтлагаар олдсон олдворыг зөвхөн судалж хамгаалах биш тэндээс шаардлагатай хэрэгтэй гэсэн зүйлсийг өнөөгийн өдөр тутмын амьдралдаа авч хэрэгжүүлэх нь чухал байна. Тиймээс олдсон олдвороо зөвхөн музейд хадгалах биш түүнийг хүмүүст таниулж хөгжүүлэх ёстойг судлаач бүр анхаарвал зохистой юм.

Ном зүй

- Амарбилэг Ч.*, 2009. Монгол нутгаас олдсон хөлөгт тоглоом. Бакалаврын дипломын ажил. МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн тэнхим. Улаанбаатар.
- Анхбаяр Б., Батболд Г.*, 2008. Чинтолгойн балгасны судалгаа (Монгол Улс-ОХУ-ын хамтарсан археологийн судалгааны “Чинтолгой” төслийн тайлан. 2004-2007). Улаанбаатар.
- Артамонов М.И.*, 1958. Саркел-Белая Вежа. Материалы и исследования по археологии СССР, № 62: Труды Волго-Донской археологической экспедиции. Том I. Москва-Ленинград, 7-84.
- Евтюхова Л.А.*, 1965. Изделие различных ремесел из Кара-Корума. Древнемонгольские города. Москва, 274-296.
- Ерөөл-Эрдэнэ Ч.*, 2007. Хүннү булшнаас олдсон хөлөгт тоглоом (Гол модны хүннү булшны хэрэглэгдэхүүнээр). *Studia Archaeologica*. Tom. (IV) XXIV, Fasc. 19, Улаанбаатар, 280-287.
- Намжилдорж Н.*, 1966. Монголын хөлөгт тоглоом (дэд дэвтэр). Улаанбаатар.
- Очир А., Крадин Н.Н., Ивлиев Д.Л., Данилов С.В., Эрдэнэболд Л., Никитин Ю.Г., Энхтөр А., Очир А., Одбаатар Ц., Анхбаяр Б., Уртнасан Э.*, 2010. Монгол-БНХАУ-ын хамтарсан археологийн экспедицийн 2009 оны хээрийн судалгааны ажлын Монголын талын урьдчилсан тайлан (Өвөр хавцалын амны 5-р дөрвөлжингийн малтлага). Улаанбаатар, Монголын Үндэсний Музейн номын сан, гар бичмэлийн сан хөмрөг.
- Рыбина Е.А.*, 1997. Шашки, “мельница”, шахматы. Археология. Древняя Русь. Быт и культура. Москва, 110-114.
- Содномжамц Д.*, 2010. Уйгурын нийслэл Хар Балгаснаас олдсон нэгэн шинэ олдворын тухай. МУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. №13 (21), Улаанбаатар, 88-101.
- Цэвээндорж Д., Эрдэнэбат У.*, 2006. Хархорумын шинэ олдвор. Манай Монгол. №1-2, Улаанбаатар, 58-64.
- Щербак А.М.*, 1959. Знаки на керамике и кирпичах из Саркела-Белой Вежи (К вопросу о языке и письменности печенегов). Материалы и исследования по археологии


- СССР, № 75: Труды Волго-Донской археологической экспедиции. Том II, Москва-Ленинград, 362-414.
- Эрдэнэбат У., Батбаяр Т.*, 2008. Монгол-Германы Орхон экспедицийн 2008 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.
- Эрдэнэбат У., Батбаяр Т.*, 2009. Монгол-Германы Орхон экспедицийн 2009 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.
- Эрдэнэбат У., Батбаяр Т., Дашидорж Б.*, 2010. Монгол-Германы Орхон экспедицийн 2010 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.
- Belenizki A.M.*, 1980. Mittelasien. Kunst der Sogden. Leipzig.
- Berger F.*, 1996. Das Muehle Brett an einem Haus in Goslar. Mitteilungen der ANISA. Vol. 17, 17-32.
- Berger F.*, 1999. Spielbretter aus Borsia in Syrien. Mitteilungen der ANISA. Vol. 19/20, 23.
- Berger F.*, 2004. From Circle and Square to the Image of the World: A Possible Interpretation for some Petroglyphs of Merels Boards. Rock Art Research. Vol. 21, No.1, 11-25.
- Bussagli M.*, 1963. Die Malerei in Zentralasien. Die Kunstschaetze Asiens. Bd. 6, Geneve : Skira.
- Semenov G.L.*, 1996. Studien zur sogdischen Kultur an der Seidenstrasse. Studies in Oriental Religions. Edited by Walther Heissig and Hans-Joachim Klimkeit. Volume 36, Harrasowitz Verlag, Wiesbaden.
- Pohl E.*, 2010. The Excavation in the Craftsmen-Quarter of Karakorum (KAR-2) between 2000 and 2005 – Stratigraphy and Architecture. Mongolian – German Karakorum Expedition. Volume 1. Excavation in the Craftsmen Quarter at the Main Road. Edited by J. Bemann, U. Erdenebat & E. Pohl. Forschungen zur Archäologie Ausseuropaeischer Kulturen. Bd. 8 Bonn Contributions to Asian Archaeology Bd.2, Reichert Verlag, Wiesbaden, 63-136.
- Mandl F.*, 1994. Die Muehlespiel-Darstellungen auf Fels in den Noerdlichen Kalkalpen. Mitteilungen der ANISA. Vol. 15, 44-65.
- Manfred A.J. Eder.*, 2003. Bagdad – Bergkristall – Benedikter. Zum Ex-oriente des Schachspiels. Begleitschrift mit Katalog Schach zur “Ex-oriente” – Ausstellung in Aachen 2003. Aachen.
- Murray H.J.R.*, 1978. A history of board-games other than chess. Haker Art Books, New York.
- Rogersdotter E.*, 2010. Tracing a neglected Heritage of Play: Report from a Field Documentation of Engraved Game Boards at the ancient site of Vijayanagara, Karnataka, South India (c. AD 1350-1565). South Asian Archaeology 2007. Proceedings of the 19th Meeting of the European Association of South Asian Archaeology in Ravenna, Italy, July 2007. Vol.II, British Archaeological Reports, Oxford, 287-296.
- Heilongmen gate-site and No.4 Building-Foundation in the Yeluebaoji Mausoleum Garden of the Liao Period in Bairin left Banner, Inner Mongolia. 2011.* Major Archaeological Discoveries in China in 2010. Cultural Relics Press, Beijing, 167-171.
- Schwegler U.*, 1992. Schalen und Zeichensteine der Schweiz. Antiqua 22. Schweizerische Gessellschaft fuer Ur- und Fruehgeschichte. Basel.
- Wollenk F.*, 1991. Ueberlegungen zum Muehlespiel. Almogaren. Vol. 21 (1), 109-123.

SUMMARY

U. Erdenebat, T. Batbayar, D. Sodnomjamts


A NEW FINDING OF THE GAME BOARD FROM KARABALGASUN

The ruin of capital city of Uighur Empire, existed in 8th-9th century AD, Ordubalyk or Karabalgasun is located in 18 km from Khotont soum centre of Arkhangai aimag, in the valley of Orkhon and Jirmentu rivers. In 2009-2010, the Mongolian-German joint archaeological expedition conducted archaeological excavation at the ruin and unearthed numbers of interesting artifacts. One of the interesting findings unearthed at the Karabalgasun is a game board engraved on the brick and glass pieces for the game. This type of board game has been known since 3500 years ago and was very popular in Africa with the name *Morabaraba* and in Europe with the name *Twelve men`s morris*. The same board game was played by Mongolians during 13th century and was named *Khonin shatar* (Sheep chess) or *Jirgee*. It`s hypothesized, that Uighurs had a broad relation with Sogdians and, through this relationship the game was spread from Europe via Middle Asia to Mongolian steppe.




Зураг 1. Хар Балгас: Тоглоомын хөлөг (a, b, c); Сийлбэртэй шагай (d)

ХАР БАЛГАСААС ОЛДСОН ХӨЛӨГТ ТОГЛООМ




Зураг 2. Хар Балгас: Тоглоомын хасаа



Зураг 3. а. Гол модны хүннү булшнаас гарсан хөлөг; б. Энэтхэгийн Чатуранга; с. Согдын Пайкенд хотын малтлагаас олдсон хөлөг




Зураг 4. а. Дэлхийд тархсан үндсэн хоёр хэлбэр; b. Nine Men's Morris (Испани, XII зуун) тоглож буй зураг (Libro de los juegos, San Lorenzo de El Escorial, Madrid)




Зураг 5. а. Өвөр Монголын нутагт малтсан кидан бунханы байгууламжаас илэрсэн олдвор;
b. Архангай аймгийн Хотонт сумын Өвөр хавцалын амны дөрвөлжингөөс илэрсэн олдвор


ХАР БАЛГАСААС ОЛДСОН ХӨЛӨГТ ТОГЛООМ




Зураг 6. ОХУ-ын өмнөд хэсэгт орших Дон мөрний эрэг дээрхи Саркел (МЭ 834-965): Малталтаар олдсон тоосгон дээрх дүрс тэмдгийн хэлбэрүүд



Зураг 7. Дундад зууны үеийн Европын хөлөгт тоглоомын хэлбэр: а. ОХУ-ын Новгород хотын орчмоос олдсон хөлөг; б. Нормандын нэгэн цайзаас олдсон хөлөг



Зураг 8. Энэтхэгийн музейд буй бурханы хөрөг (Ханын зураг)




Зураг 9. а. X зууны үеийн Дундад Азийн домгийн амьтны дүрст согд торгоны хээнд Хар Балгасын тоглоомын хөлөгтэй төслөг дүрс мэдэгдэнэ;



b.

Зураг 9. б. Дорнод Туркестаны Куча дахь VII зууны сүмийн дээврийн чимэглэл зурагт байгаа хээ тэмдгийн доторх дүрслэл



Зураг 10. Монгол ардын уламжлалт хөлөгт тоглоом: а. Алтан хараацай, б. Гургалдай, с. Давхар жиргэ, d. Олбог, e. Хонин шатар, f. Таван тал, г. Үүд, h. Жиргэмэл